



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

177.	Цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад байх объектын жагсаалт батлах тухай	Дугаар 91	637
178.	2013 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай	Дугаар 92	639
179.	Авто замын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх тухай	Дугаар 96	639

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 3 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 91

Улаанбаатар
хот

Цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад байх объектын жагсаалт батлах тухай

Дотоодын цэргийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад байх онц чухал объектын жагсаалтыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Цагдаа, дотоодын цэргийн төсөвт хамгаалалтад шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Хууль зүйн сайд Х.Тэмүүжин, Сангийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад байх объектын жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2004 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 135 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

ХУУЛЬ ЗҮЙН САЙД

Х.ТЭМҮҮЖИН



Засгийн газрын 2013 оны 91 дүгээр
тогтоолын хавсралт

ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН ХАМГААЛАЛТАД БАЙХ
ОНЦ ЧУХАЛ ОБЪЕКТЫН ЖАГСААЛТ

Нэг. Дотоодын цэргийн төсөвт хамгаалалтад байх объект

1. Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн төв байр, радио, телевизийн эфирийн студи, Хонхор дахь дамжуулах байгууламжийн радио, телевизийн техникийн төв;

2. Мэдээллийн “МОНЦАМЭ” агентлаг;

3. “Изотоп” төв;

4. Улаанбаатар, Чойбалсан хотын ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж;

5. Дархан хотын ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж;

6. Эрдэнэт хотын ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж;

7. Ховд хотын ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж;

8. Даланзадгад хотын ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж;

9. “Дулааны III цахилгаан станц”, “Дулааны IV цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компаниуд;

10. Дөргөний усан цахилгаан станц;

11. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн төв лаборатори;

12. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн лаборатори;

13. Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори;

14. Зоонозын өвчин судлалын үндэсний төв;

15. “Биокомбинат” төрийн өмчит үйлдвэрийн газар;

16. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газар;

17. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн;

18. Татварын ерөнхий газрын төв байр;

19. Стандартчилал, хэмжил зүйн газрын төв байр;

20. Алтан-Өлгий дэх оршуулгын газар.

Хоёр. Дотоодын цэргийн гэрээт хамгаалалтад байх объект

1. Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэр, дарь, дэлбэрэх бодисын үйлдвэр, тэсэрч дэлбэрэх бодисын агуулах;

2. “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүс;

3. “Цагааннуур” худалдааны чөлөөт бүс.



Гурав. Цагдаагийн төсөвт хамгаалалтад байх объект

1. Гадаадын Дипломат төлөөлөгчийн газар;
2. НҮБ-ын суурин төлөөлөгчийн газар;

3. “Монголын хөрөнгийн бирж”, “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК;

4. Улсын бүртгэлийн ерөнхий газрын төв болон үйлчилгээний байрууд, Иргэний цахим үнэмлэхийн үйлдвэр.

Дөрөв. Цагдаагийн гэрээт хамгаалалтад байх объект

1. Монгол банк.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 3 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 92

Улаанбаатар
хот

2013 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай

Амьтны тухай хуулийн 26.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Тусгай зориулалтаар 2013 онд угалз 15, тэх 32, халиун буга 10, саарал чоно 50, бор гөрөөс 40, зэрлэг гахай 10 толгойг агнуулах, 200 толгой тул загас барьж буцаан тавиулахаар тус тус тогтоосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**БАЙГАЛЬ ОРЧИН,
НОГООН ХӨГЖЛИЙН САЙД**

С.ОЮУН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 3 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 96

Улаанбаатар
хот

Авто замын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх тухай

Улсын Их Хурлын 2011 оны 15 дугаар тогтоол, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:



1. Өмнөговь, Хөвсгөл, Дорнод аймгийг Улаанбаатар хоттой хатуу хучилттай авто замаар холбох зорилгоор Засгийн газрын үнэт цаасыг арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөс санхүүжүүлэн гүйцэтгэх зам барилгын ажлын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тогтоолын хавсралтад заасан зам барилгын ажил болон зөвлөх үйлчилгээг Хөгжлийн банкаар дамжуулан санхүүжүүлэхийг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Сангийн сайд Ч.Улаанд даалгаж, Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Шинэбаатар)-д зөвшөөрсүгэй.

3. Хөгжлийн банкны зээлийг эргэн төлөхөд шаардагдах хөрөнгийг тухай бүр нь улсын төсөвт тусган шийдвэрлэж байхыг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Сангийн сайд Ч.Улаан, Зам, тээврийн сайд А.Гансүх нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД

А.ГАНСҮХ

Засгийн газрын 2013 оны 96 дугаар
тогтоолын хавсралт

**ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСЫГ АРИЛЖААЛЖ БҮРДҮҮЛСЭН
ХӨРӨНГӨӨС САНХҮҮЖҮҮЛЭН ГҮЙЦЭТГЭХ ЗАМ
БАРИЛГЫН АЖЛЫН ЖАГСААЛТ**

№	Баригдах авто зам	Урт (км)	Хэрэгжүүлэх хугацаа
1	Мандалговь-Даланзадгад чиглэлийн хатуу хучилттай авто зам	25	2013 он
2	Мандалговь-Даланзадгад чиглэлийн хатуу хучилттай авто зам	25	2013 он
3	Мөрөн-Тариалан чиглэлийн хатуу хучилттай авто зам	32	2013 он
4	Мөрөн-Тариалан чиглэлийн хатуу хучилттай авто зам	25	2013 он
5	Мөрөн-Тариалан чиглэлийн хатуу хучилттай авто зам	29.3	2013 он
6	Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн хатуу хучилттай авто зам	30	2013 он
7	Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн хатуу хучилттай авто зам	27	2013 он
8	Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн хатуу хучилттай авто зам	27.75	2013 он
9	Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн хатуу хучилттай авто зам	10.65	2013 он
НИЙТ		231.7	

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turii_medecelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 0.25

Индекс: 14003